

ДАРХАН УУЛ АЙМГИЙН МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН АЛБАНЫ  
2016 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2016 оны 06 дугаар сарын 24

Дархан-Уул аймаг

№	Тусгай захиалгат бүтээгдэхүүнээс бусад нийлүүлвэл зохих нийт бүтээгдэхүүний нэр төрөл, шалгуур үзүүлэлт бүрээр хүрэх түвшин	Жинхэнэ гүйцэтгэл, шалгуур үзүүлэлт бүрээр хүрсэн түвшин
1	1	2
<b>НЭГ. БАЙГУУЛЛАГА (НЭГЖ)-ЫН СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ</b>		
<b>1.1 Хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа</b>		
1	1.1.1 Аймгийн албан ёсны цахим хуудасны мэдээллийн тогтмол шинэчлэх	Аймгийн албан ёсны <a href="http://darkhan.gov.mn">darkhan.gov.mn</a> цахим хуудас болон Дархан хот /5966 дагагчтай/, Дархан-Уул аймгийн Засаг даргын тамгын газар /3143 дагагчтай / фэйсбүүк цахим хуудсанд аймгийн өдөр тутмын үйл явдалтай холбоотой нийт 511 мэдээг байршуулж, мөн дүрст мэдээ 310-ыг бэлтгэн иргэдэд нээлттэй хүргэсэн.
2	1.1.2 Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудад зар мэдээг тогтмол хүргэх	Орон нутгийн RGB, DBS, Lkha, TV12 телевизүүд болон, <a href="http://darkhan.gov.mn">darkhan.gov.mn</a> цахим хуудас болон Дархан хот /5966 дагагчтай/, Дархан-Уул аймгийн Засаг даргын тамгын газар /3143 дагагчтай/ фэйсбүүк хуудсаар нийт 20 өдөр тутмын үгэн зарыг тогтмол хүргүүлж ажилласан.
3	1.1.3 Шууд болон тусгай нэвтрүүлгүүдийг бэлтгэж нийтэд цацах	“Нээлттэй төр” 6, “Сэтгүүлчийн цаг” 4 цуврал нэвтрүүлэг бэлтгэж орон нутгийн дөрвөн телевизээр тогтмол цагт явуулж иргэдийн хүртээл болгосон. Мөн “Дарханы хөгжил олон улсын эдийн засгийн форум-2016”-ын тусгай 6 дугаарыг тус тус бэлтгэн нийт 16 нэвтрүүлэг гаргасан байна.
4	1.1.4 Төвийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр орон нутгийн үйл ажиллагааны талаар мэдээлэл хүргэх	Төвийн хэвлэл мэдээллийн Монголын Үндэсний олон нийтийн радио телевиз, ТВ-9, ТВ-5, Молор, ETV, Өлзий телевизүүдэд орон нутгийн үйл явдлын 50 онцлог ажлын мэдээллийг хүргэсэн. Мөн Сайтын холбоотой байгуулсан гэрээний дагуу мэдээллийн томоохон сайтуудаар 151 удаагийн 7.550.000 төгрөгийн мэдээ мэдээллийг хүргэж ажилласан. /Хагас жилээр гэрээг дүгнэсэн. “Бурхантын цуурай” радиотой байгуулсан гэрээний хүрээнд Монцамэ агентлагт мэдээллийг нийтлүүлж байна. Хагас жилээр гэрээг дүгнэсэн.
5	1.1.5 Сонин хэвлэлд мэдээлэл бэлтгэж нийтлүүлэх	Аймгийн сар тутмын /3000 ширхэг/ мэдээллийн "Дарханы мэдээ" сонинг Мэдээлэл технологийн албанаас эрхлэн гаргаж хэвшээд байна. 1-5 дугаар сард нийт 15.000 ширхэг сонинг Дархан-Уул аймгийн 4 сумд, шуудангийн хайрцагаар дамжуулан

		<p>үнэгүй тараан аймаг орон нутгийн үйл ажиллагааг иргэд олон нийтэд мэдээллэж байна.</p> <p>“Эзэгтэй таны туслах” сэтгүүлтэй гэрээ байгуулан аймаг орон нутгийн мэдээ мэдээллийг Фокус Дархан сар тутмын сэтгүүлд хэвлүүлэн гаргадаг боллоо.</p> <p>3 дугаар сард “Дарханы хөгжил Олон Улсын эдийн засгийн форум-2016”-ийн хүрээнд Фокус Дархан сэтгүүлийн тусгай дугаарыг нэмэлтээр хэвлүүлэн гаргаж ажилласан. Тус сэтгүүл аймгийн хэмжээнд сар бүр 2000 ширхэг хэвлэглэн үнэ төлбөргүй тараагдаж иргэдийн хүртээл болж байна. “Шинэ мэдээ”, “Дархан таймс” зэрэг орон нутгийн сонинуудад цаг үеийн мэдээ мэдээллийг нийтлүүлж байна.</p> <p>Мөн Дархан-Уул аймгийн албан ёсны танилцуулгын эхийг шинэчлэн бэлтгэж 3000 ширхэгийг хэвлүүлсэн. Тус танилцуулгыг гадаад дотоодын зочид төлөөлөгчдөд аймаг орон нутгаа сурталчилах, танилцуулах зорилгоор дурсгаж байна.</p>
--	--	--

**1.2 Техник, тоног төхөөрөмжийн хэвийн байдлыг хангах үйл ажиллагаа**

6	1.2.1 Аймгийн ЗДТГ-ын хурлын танхимын техник тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах	Аймгийн Засаг даргын тамгын газрын хурлын танхимд батлагдсан хуваарийн дагуу болдог Удирдах ажилтны зөвлөгөөн, Сум агентлагын дарга нарын зөвлөгөөн, ИТХ-ын ээлжит хуралдаан, ИТХ-ын дэргэдэх Иргэний танхимын “Нээлттэй хэлэлцүүлэг” болон бусад хэлтэс албадын сургалт семинар зэрэг нийт <b>124</b> үйл ажиллагааны үеэр хурлын танхим болон техник хэрэгслийн үйл ажиллагааны хэвийн байдлыг ханган ажилласан байна.
7	1.2.2 “Дархан-50” цогцолборын дэлгэцийн хэвийн ажиллагааг хангах	2016 оны эхний хагас жилд нийт 12 удаагийн үйл ажиллагааны үеэр “Дархан-50” цогцолборын дэлгэцийн хэвийн ажиллагааг ханган ажилласан. Тухайлбал: Аймгийн “Мөнгөн өвөл” нэгдсэн шинэ жил, “Нийгмийн үйлчилгээг танд” аяны нээлт, “Нэг тэрбумаараа тэмцье” эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт зориулсан жагсаал, “Цэргийн хүрээний жагсаал”, “Дархан марафон 2016” гүйлт, “Хэрэглэгчийн жил”-ийн өдөрлөг, “Аз жаргалтай гэр бүл” өдөрлөг, “Жаргалтай Дарханы хүүхдүүд”, Хувийн хэвшлийн сургууль, цэцэрлэгийн өдөрлөг, Мөнгөн хонх зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг зохион байгуулахад дэлгэцийн хэвийн ажиллагааг хангаж ажилласан.

<b>1.3 Аймгийн ЗДТГ болон бусад гэрээт байгууллагуудын мэдээлэл технологийн үйл ажиллагаа</b>		
8	1.3.1 Аймгийн ЗДТГ-н интернет болон дотоод сүлжээний хэвийн үйл ажиллагааг хангах	Аймгийн Засаг даргын Тамгын газар болон бусад гэрээт байгууллагуудын сүлжээ татах, сүлжээний гэмтэл доголдол арилгах, хэвийн ажиллагааг хангах 15 дуудлагаар ажиллаж албан хаагчид мэргэжилтнүүдэд зөвлөн тусалсан байна.
9	1.3.2 Компьютер, техник хэрэгслийн хэвийн ажиллагааг хангах	Аймгийн Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын Тамгын газрын байранд байрлах гэрээт байгууллагуудын албан хаагчдын компьютерийн засвар үйлчилгээний 45 дуудлагаар ажиллаж албан хаагчид мэргэжилтнүүдэд зөвлөн тусалсан байна.
10	1.3.3 Гэрээт байгууллагуудын интернетийн хэвийн ажиллагааг хангах	Интернетийн гэрээтэй аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэдэх Орон нутгийн өмчийн алба, Захирагчийн ажлын алба, Худалдан авах ажиллагааны алба зэрэг төрийн байгууллагуудийн интернетийн тасралтгүй хэвийн ажиллагааг ханган 5 дуудлагаар ажиллаж албан хаагчид мэргэжилтнүүдэд зөвлөсөн.
<b>1.4 Төрийн нэгдсэн сүлжээний хэвийн үйл ажиллагаа</b>		
11	1.4.1 Төрийн болон төрийн өмчит байгууллагуудын интернетийн үйл ажиллагаа	Төрийн болон төрийн өмчит байгууллагуудын интернетийн үйл ажиллагааг тогтмол хэвийн ажиллуулж байна. Байгууллагын дотоод сүлжээний хэвийн үйл ажиллагааг ханган ажиллуулах ажлын хүрээнд “Цахим орчин” ХХК-аас тоног төхөөрөмж худалдан авах гэрээний дагуу интернэт сүлжээний CISCO Management swicth-ийг авч суурилууллаа. Энэ төхөөрөмж нь байгууллагын интернэт тасалдахгүй хэвийн байхад чухал үүрэг гүйцэтгэж байна.
12	1.4.2 Төрийн нэгдсэн сүлжээний хэвийн үйл ажиллагаа	Төрийн нэгдсэн сүлжээний хэвийн үйл ажиллагааг аймгийн Цагдаагийн газартай хамтран хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна.
<b>1.5 Нийтийг хамарсан ажлыг зохион байгуулах</b>		
13	1.5.1 Улсын баяр наадам, цагаан сарын баяр наадамн үйл ажиллагааг зохион байгуулахад хамтран ажиллах	Сар шинийн баярын Цагаан сар үзэсгэлэн худалдааны мэдээллийн ивээн тэтгэгчээр ажилласаны зэрэгцээ аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарын Сар шинийн мэндчилгээг бичиж боловсруулсан. Уг мэндчилгээний зураг авалт хийж, ТВ, сонин, сайтын хэлбэрээр иргэд олон нийтэд түгээсэн. Баярын өдрүүдэд аймгийн удирдлагуудын хамт ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх, аймгийн Хөдөлмөрийн аваргуудад шагнал гардуулах ёслол, Төрийн нэгдсэн золголт, Мандал өргөх үйл ажиллагааны мэдээллийг бэлтгэсэн. Улс тунхагласаны 95 жилийн ой, Дархан-Уул аймгийн 55 жилийн ойн үндэсний баяр наадмыг зохион байгуулах ажлын хэсгийн комиссын бүрэлдэхүүнд орж ажиллаж байна.

--	--	--

## 2 ТУСГАЙ ЗАХИАЛГАТ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Нийлүүлвэл зохих тусгай захиалгат бүтээгдэхүүний нэр төрөл, шалгуур үзүүлэлт бүрээр хүрэх түвшин	Жинхэнэ гүйцэтгэл, шалгуур үзүүлэлт бүрээр хүрсэн түвшин
	1	2
<b>2.1. “Смарт Дархан” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа</b>		
14	2.1.1. Байгууллагын дотоод удирдлагын системийг нийт төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд нэвтрүүлж ажиллах	<p>Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 101 дүгээр тогтоолоор батлагдсан “Цахим Засаг” үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Смарт Дархан” аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулан аймгийн ИТХ-ын 2014 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 30 дугаараар тогтоолоор батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд Дархан-Уул аймгийн бүх төрийн байгууллагуудад “Ханлиг” төрийн байгууллагын дотоод удирдлагын цахим системийг нэвтрүүлэхээр туршиж байна. Тус системийг хэрхэн ашиглах, мэдээллэх сургалтыг нийт 2 удаа төрийн байгууллагуудын удирдах албан тушаалтнууд, мэдээлэл технологийн мэргэжилтэн, хүний нөөцийн ажилтан, бичиг хэргийн эрхлэгч нарт зохион байгуулсан. Тус системийг нэвтрүүлэгч “Эн Эм Эй” ХХК нь тендерт шалгаран гэрээ байгуулан ажиллаж байна.</p> <p>Мөн ХШҮнэлгээний мониторингийн програмыг “Санхүүгийн тооцоолох төв”-с аймгийн ЗДТГазарт нэвтрүүлэх судалгааны ажил хийгдэн ХШҮТасагтай хамтран ажиллаж эхлээд байна.</p>
<b>2.2. Төсвийн тухай болон Шилэн дансны тухай хууль, тэдгээртэй холбогдон гарсан заавар журмыг хэрэгжүүлэх</b>		
15	2.2.1 Аймгийн шилэн данстай холбоотой мэдээллийг цахим хуудсанд байрлуулж мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах	<p>Аймгийн Засаг даргын Тамгын газрын шилэн дансны мэдээллийг <a href="http://darkhan.gov.mn">darkhan.gov.mn</a> цахим хуудсанд тусгай цэс үүсгэн иргэдэд нээлттэй мэдээллэж байна.</p> <p>Мөн аймаг орон нутгийн төсвийн талаарх долоо хоног, сар, улирлын тоон мэдээг СТСХэлтсээс авч сайтад тогтмол байршуулж байна.</p> <p>Өөрийн сайтанд Монгол банкны Дархан-Уул, Сэлэнгэ аймгуудын банкуудын зээл хадгаламжийн мэдээг тогтмол оруулж ажилладаг.</p>
<b>2.3. Монгол Улсын Засгийн газар болон Аймгийн Засаг даргын тамгын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах</b>		
16	2.3.1 МУЗГ болон Аймгийн Засаг Даргын үйл ажиллагааны хөтөлбөрт өөрийн байгууллагын эрхлэх асуудлын чиглэлээр тусгагдсан зорилт арга	<p>Аймгийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Мэдээлэл технологийн албатай холбоотой 4 асуудал тусгагдсан ба үүнд:</p> <p>2014 оны 4 дүгээр сард аймгийн албан ёсны</p>

	<p>хэмжээнүүдийн хэрэгжилтийг хангаж ажиллах</p>	<p>darkhan.gov.mn цахим хуудсыг ажиллуулж эхэлсэн ба төрийн 22 байгууллагын цахим хуудсыг холбон аймгийн ЗДТГ-ын явуулж байгаа бүх төрлийн ажил үйлчилгээ, үйл ажиллагааны чанарын талаарх мэдээлэл танилцуулга, бусад материалыг цахим хуудсаар дамжуулан иргэдэд төрийн мэдээллийг нээлттэй хүргэж байна.</p> <p>Дархан-Уул аймгийн Цагдаагийн газар нь Төрийн нэгдсэн сүлжээний арчлалт хамгаалалтыг тухай бүр хийж ажиллаж байна.</p> <p>Цахим хуудсанд ирсэн иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч, холбогдох албан тушаалтанд хүргүүлж ажиллаж байна.</p> <p>Хагас жилийн байдлаар ..... санал гомдол онлайн хэлбэрээр ирсэн байна.</p>
17	<p>2.3.2 ДУА-ийн аймгийн ИТХ-ын тогтоолоор батлагдсан болон Үндэсний хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлж ажиллах</p>	<p>Аймгийн ИТХ-ын 2014 оны 30 дугаар тогтоолоор “Смарт Дархан” аймгийн дэд хөтөлбөрийг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд Дархан-Уул аймгийн бүх төрийн байгууллагуудад “Ханлиг” төрийн байгууллагын дотоод удирдлагын цахим системийг нэвтрүүлэхээр туршиж байна. Тус системийг хэрхэн ашиглах, мэдээллэх сургалтыг нийт 2 удаа төрийн байгууллагуудын удирдах албан тушаалтнууд, мэдээлэл технологийн мэргэжилтэн, хүний нөөцийн ажилтан, бичиг хэргийн эрхлэгч нарт зохион байгуулсан. Тус системийг нэвтрүүлэгч “Эн Эм Эй” ХХК нь тендерт шалгаран гэрээ байгуулан ажиллаж байна.</p> <p>Аймгийн хэмжээнд төрийн өмчийн ерөнхий боловсролын нийт 14 сургуульд “Шилэн сургууль” программ хангамжийг 99.1 сая төгрөгийн санхүүжилтээр хийж нэвтрүүллээ. Ингэснээр сургууль, багш, эцэг эх, асран хамгаалагчидын хооронд шуурхай мэдээлэл солилцох асуудлыг онлайн орчинд буюу дэвшилтэд технологийг ашиглан шийдвэрлэснээр тэдгээрийн хамтын ажиллагааг сайжруулахад ахиц гарлаа.</p> <p>Аймгийн Засаг дарга “Ухаалаг-ирээдүй-2016” боловсролыг дэмжих төслийг санаачлан “Юнайтэд консалтинг менежмент” ХХК-тай хамтран зохион байгуулснаар манай аймагт энэ онд төгсөж байгаа ахлах ангийн 1437 суралцагчдад ирээдүйн мэргэжлээ сонгоход нь томоохон дэмжлэг болж, Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нэгдүгээр зэрэглэлийн</p>

		мэргэжлийн сонирхол, карьерын чиг баримжааг үнэлэх 53 евро буюу 120 мянган төгрөгийн үнэтэй тестэд төгсөгчдийг үнэ төлбөргүй хамруулсан. Энэ нь суралцагчдыг ирээдүйн мэргэжлээ зөв сонгоход нь ихээхэн ач холбогдолтой арга хэмжээ боллоо.
<b>2.4. Зохион байгуулагдах сургалт семинарт оролцсон тайлан мэдээг тухай бүр тайлагнаж ажиллах</b>		
18	2.4.1 Гадаад оронд зохион байгуулагдах сургалт, семинарт оролцохдоо Засгийн газрын хэрэг эрхлэх газраас зөвшөөрөл авч, томилолтоор ажилласан үр дүн болон өөр аймаг, нийслэлд ажиллах талаар АЗДТГ-н Төрийн захиргаа удирдлагын хэлтэст тухай бүр тайлагнаж мэдэгдэх	Гадаад оронд томилолтоор явсан ажил байхгүй.
<b>2.5 Гаргасан захирамж, тушаалыг хянуулах</b>		
19	2.5.1 Сум, агентлагийн дарга нарын захирамж, тушаалыг улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор ирүүлж хянуулах, зөвлөмжийн дагуу зөрчлийг арилгуулж, хариуг тухай бүрт нь АЗДТГ-ын Хууль зүйн хэлтэст ирүүлэх	2016 онд Мэдээлэл технологийн албаны ажилтнуудтай байгуулах Хөдөлмөрийн гэрээг байгуулан баталгаажуулан ажиллаж байна. Албаны даргын 2016 оны нийт 5555 тушаал, болон ажил байдлын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээ болон байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ зэрэг албаны эрх зүйн баримт бичгүүдийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн мэргэжилтнээс зөвлөгөө аван хянуулан ажилласан.
<b>2.6 Байгууллагын дотоод үйл ажиллагаандаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлуудыг зохион байгуулж ажиллах</b>		
20	2.6.1 Байгууллагынхаа дотоодод болон үйл ажиллагааныхаа чиглэлээр гэмт хэрэг, зөрчил, архидан согтуурахтай тэмцэх, авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажил зохион байгуулж, хагас, бүтэн жилээр аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтэст тайлагнана.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлтэй хамтран мэдээлэл бэлтгэн орон нутгийн 4 телевизээр иргэдэд хүргэж ажилласан. ИТХ-ын дэргэдэх ГХУСАЗЗ, Ардчилсан залуучуудын холбоо хамтран “Өсвөр үеэ мансуурлаас сэргийлье” уриан дор хоёр сарын аяныг 2016 оны нэг, хоёрдугаар сард амжилттай өрнүүлсэн. Уг аяныг санаачилсан бөгөөд Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, аймгийн Мэдээлэл технологийн алба зэрэг төрийн болон төрийн бус байгууллагууд нэгдэн ажилласан байна. Аймгийн Мэдээлэл технологийн албаны даргаар ахлуулсан ажлын хэсэг нь аяны хүрээнд ЕБС-иудын ахлах ангийн сурагчдад мансууруулах бодисын хор нөлөөг таниулах, мансууруулах бодистой тэмцэх хууль эрх зүйн орчныг таниулан сурталчилах арга хэмжээг эн тэргүүнд хэрэгжүүлж, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх тухай сургалтыг явуулж, 4900 гаруй сурагчдыг хамруулсан зэрэг олон ажлуудыг өрнүүлсэн. Үүнтэй холбоотой мэдээ, мэдээллийг аймгийн Мэдээлэл технологийн алба нь албан ёсны фэйсбүүк хуудас болох 5860 дагагчтай Дархан

		хот, 3123 дагагчтай Дархан-Уул аймгийн Засаг даргын тамгын газар, 5000 найзтай Дархан хот гэсэн фэйж хуудсуудаар дамжуулан олон нийтэд хүргэн ажилласан. Мөн төвийн Молор, ТВ9, Өлзий телевизүүд болон орон нутгийн Лха, Ди Би Эс, Аа Жи Би, TV12 телевизүүд, Монцамэ агентлагийн төвийн бүсийн хэвлэлийн төлөөлөгчөөр тус тус дамжуулан иргэдэд мэдээллэсэн.
<b>2.7 Хугацаатай тайлан мэдээг цаг тухай бүр ирүүлэх</b>		
21	2.7.1 Хугацаатай тайлан, мэдээг АЗДТГ-ын даргын баталсан “АЗДТГазарт 2016 онд ирүүлэх тайлан, мэдээний хуваарь”-ийн дагуу хугацаанд нь ирүүлнэ.	Мэдээлэл технологийн албаны 7 хоногийн ажлын төлөвлөгөө, тайлан болон хугацаат тайлан мэдээг цаг тухайд нь гаргаж ажиллаж байна. Хугацаатай тайлан, мэдээг АЗДТГ-ын даргын баталсан “АЗДТГазарт 2016 онд ирүүлэх тайлан, мэдээг хуваарь”-ийн дагуу хугацаанд нь тогтмол хүргүүлэн ажиллаж байна.

### 3. ДОТООД АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Дотоод үйл ажиллагааны зорилтууд, тэдгээрийн шалгуур үзүүлэлт	Жинхэнэ гүйцэтгэл, шалгуур үзүүлэлт бүрээр хүрсэн түвшин
	1	2
22	3.1 Албаны бичиг баримт, дотоод үйл ажиллагааг хэвийн зохион байгуулж ажиллана.	Албанд болон удирдлагаас цохогдож ирсэн нийт 55 бичиг ирснээс хариутай 5 албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүллээ. Мөн албанаас нийт 37 бичгийг байгууллагуудад хүргүүлэн ажилласан байна. Чанарын удирдлагын тогтолцоог албандаа хэрэгжүүлж эхэлсэнээр бичиг баримтын бүртгэл, албан бичгийн эмх цэгц, хадгалалтыг сайжруулан ажиллаж байна. Дотооддоо зохион байгуулагддаг үйл ажиллагаандаа хөтлөх 10 бүртгэлийг тогтмол хийхээр ажиллаж байна.
23	3.2 Санхүүгийн үйл ажиллагааг хэвийн хэмжээнд хариуцан ажиллах	Албаны санхүүгийн хэвийн ажиллагааг ханган ажилласан. 2016 оны төсвийн тодотголыг шинэчлэн хийж батлуулаад байна.